Энглийн III ангилалын зуултын гажигтай хүмүүсийн инээмсэглэлийн зарим үзүүлэлтүүдийг судалсан дүн

Г.Хулан[1], Б.Од[2]
[1]АШУУИС-ийн Нүүр Ам Судлалын Сургууль,
[2]НАГЗТ
Цахим шуудан: hulanganbold2@gmail.com
Утас: 99031029

Түлхүүр үг:
Энглийн III ангилал, инээмсэглэлийн үзүүлэлт

Товч утга

Үндэслэл: Улаанбаатар хотод хийгдсэн судалгаануудын дүнгээс харахад гажгийн тархалт 1983 онд 64.6%, 2004 онд 87%, 2011 онд 85.9%, 2020 онд 94.1% байгаа нь нүүр амны гажгийн тархалт нэмэгдэх хандлагатай бөгөөд үүниийг дагаад гажиг заслын эмчилгээний хэрэгцээ нэмэгдэж байна. Гажиг заслын эмчилгээ нь шүдний байрлал, зуултын харьцаа, үйл зүйд анхаарлаа хандуулдаг. Гэсэн хэдий ч үйлчлүүлэгчид нүүрний гоо зүй, ялангуяа инээмсэглэлийн гоо зүйн талаар санаа зовдог байгаа талаар олон судалгаагаар дурджээ.

Зорилго: Энглийн III ангилалын зуултын гажигтай хүмүүсийн инээмсэглэлийн зарим үзүүлэлтүүдийг судлахад оршино.

Арга, аргачлал: Бид Мон Тайм Лайм төслийн хүрээнд хамрагдсан хүмүүсийн үзлэгийн картыг ашиглан дүн шинжилгээ хийсэн. Судалгаанд хамрагдагсадыг насаар нь 1-р бүлэг (20-24 нас), 2-р бүлэг (25-29 нас), 3-р бүлэг (30-34 нас) гэсэн 3 бүлэгт хуваасан. Үзлэгийн картнаас хүн ам зүйн мэдээлэл, араа шүдний хоршилт, инээмсэглэлийн нум, инээмсэглэлийн хэлбэр, инээмсэглэлийн тэгш хэм, хацрын корридор болон тайван үеийн хоншоорын үүдэн шүдний харагдах байдал зэрэг үзүүлэлтүүдийг ашигласан. Судалгааны статистик боловсруулалтыг STATA программыг ашиглан дескриптив судалгааны аргаар хийж гүйцэтгэв.

Үр дүн: Нийт судалгаанд хамрагдагсадын инээмсэглэлийн нум нь нийцтэй, инээмсэглэлийн хэлбэр нь их болон дунд үзүүлэлтүүд, хацрын корридор нь харагдах байдал нь илүү ажиглагдсан. Мөн тайван үед хоншоорын үүдэн шүд нь харагдахгүй байдал нь тодорхойлогдсон байна.

Дүгнэлт: Энглийн III ангилалын зуултын гажгийн үед илрэх инээмсэглэлийн зарим үзүүлэлтүүдийн шинж тэмдгүүд нь инээмсэглэлийн үзүүлэлтүүдийн гоо зүйн хувьд нийцэж байгаа бөгөөд нас ахих тусам инээмсэглэлийн зарим үзүүлэлтүүдийн тохиромжтой шинж чанар нь буурдаг байна. Энглийн III ангилалын зуултын гажгийн үед эрүүний араа шүдний хоршилт урагшилсанаас болон хоншоор ясны дутуу хөгжил зэргээс шалтгаалан инээмсэглэх үед хацрын корридорын харагдах байдал илүү байгааг харуулж байна.

Үндэслэл: Инээмсэглэл бол хүний сэтгэл татам төрхний үнэ цэнийг нэмэгдүүлдэг нүүрний хамгийн чухал илэрхийллүүдийн нэг юм.[1] Гажиг заслын эмчилгээ нь шүдний байрлал, зуултын харьцаа, үйл зүйд анхаарлаа хандуулдаг. Гэсэн хэдий ч үйлчлүүлэгчид нүүрний гоо зүй, ялангуяа инээмсэглэлийн гоо зүйн талаар санаа зовдог. Инээмсэглэлийн үзүүлэлтүүд нь нүүрний хатуу болон зөөлөн эдийн харилцаа хамаарлыг тодорхойлох гоо зүйн үнэлгээ юм.[2,3] Тохиромжтой инээмсэглэл гэж байдаггүй. Харин гоо зүйн хамгийн чухал зорилго нь тэнцвэртэй инээмсэглэлийг бий болгох бөгөөд үүнийг шүд болон буйл, зөөлөн эдэд зохицсон байрлал гэж тодорхойлно.[4] Нүүрний гоо зүйд инээмсэглэлийн нумын ач холбогдлыг харуулсан судалгаанд гүдгэр буюу нийцтэй инээмсэглэлийн шугам нь урвуу буюу нийцтэй бус инээмсэглэлийн шугамаас илүү гоо зүйн шинж чанартай гэж тодорхойлсон байдаг.[5] Фруш, Фишер, Жеймсон нарын судалгаагаар дундаж гэх үзүүлэлтийг инээмсэглэлийн хэлбэрийн тохиромжтой төрөл хэмээн тодорхойлсон.[6] Зарим судлаачид хацрын корридорын харагдах байдал нь гоо зүйд чухал биш гэж үзсэн боловч Мортеза хэмээх судлаачийн судалгаанд хацрын корридор харагдах байдал нь тааламжгүй хэмээн тодорхойлсон.[7] Тайван үед хоншоорын үүдэн шүдний харагдах хэмжээ нас нэмэгдэхийн хэрээр багасдаг тул энэ нь гоо зүйн чухал үзүүлэлтийн нэг юм.[8] Иймээс эмч нар үйлчлүүлэгчийн инээмсэглэлийн гоо зүйн байдлыг үнэлэх чадвартай байх нь маш чухал юм.

Хоншоорын яс ба эрүүний яс, хоншоорын шүд ба эрүүний шүд хоорондоо хэвийн бус харьцахыг нүүр амны гажиг гэнэ. Зуултын гажгийг Энглийн ангиллаар I, II, III гэж ангилна. Улаанбаатар хотод хийгдсэн судалгаануудын дүнгээс харахад Энглийн ангиллын дагуу зуултын гажгуудын тархалтыг үнэлэхэд Энглийн I ангилал 52.8%, Энглийн II ангилал 42.1%, Энглийн III ангилал 5.1% байна.[9,10]

Зуултын гажиг нь амьдралын чанарт сөргөөр нөлөөлдөг гэсэн судалгаа байдаг. Тэдгээрийн үр дүнд зуултын гажигтай хүмүүст нийгмийн болон сэтгэлзүйн нөлөөлөл ихтэй байсан нь ажиглагдсан.[11] Гэвч зуултын гажигтай хүмүүсийн инээмсэглэлийн үзүүлэлтүүдийг судалсан судалгаанууд Монголд төдийгүй дэлхий дахинд цөөн байдаг.

Тиймээс зуултын гажигтай хүмүүсийн инээмсэглэлийн зарим үзүүлэлтийг судалснаар нүүр амны гажиг засал төдийгүй бусад салбар шинжлэх ухааны оношилгоо, эмчилгээний төлөвлөгөө, эмчилгээний үр дүнг нэмэгдүүлэх мөн нотолгоонд суурилсан суурь судалгаа болоход тодорхой хувь нэмэр оруулах ач холбогдолтой тул энэхүү судалгааг хийх үндэслэл болсон.

Зорилго: Энглийн III ангилалын зуултын гажигтай хүмүүсийн инээмсэглэлийн зарим үзүүлэлтүүдийг судлахад оршино.


Арга, аргачлал: Монгол хүн амын дундах эрүү нүүрний гажиг, нойрны эмгэгийн тархалт, тэдгээрийн эмнэлзүйн онцлог хоорондын хамаарлыг харьцуулсан дүн болон түүний эмчилгээ" төслийн хүрээнд уг судалгаанд 1863 хүн хамрагдсан бөгөөд тухайн судалгааны үзлэгийн картыгашигландүншинжилгээхийсэн. АШУҮИС-ийн Ёс Зүйн Хороогоор хэлэлцүүлж(протоколын дугаар 20220309), судалгаа хийх зөвшөөрөл авсны үндсэн дээр судалгааг хийсэн. Судалгаанд хамрагдагсадаас хамруулах шалгуур хангасан хүмүүсийг насаар нь 1-р бүлэг (20-24 нас), 2-р бүлэг (25-29 нас), 3-р бүлэг (30-34 нас) гэсэн 3 бүлэгт хуваасан. Үзлэгийн картнаас хүн ам зүйн мэдээлэл, араа шүдний хоршилт, инээмсэглэлийн нум, инээмсэглэлийн хэлбэр, инээмсэглэлийн тэгш хэм, хацрын корридор, тайван үеийн хоншоорын үүдэн шүдний харагдах байдал зэрэг үзүүлэлтүүдийг ашигласан. Судалгааны статистик боловсруулалтыг STATA программыг ашиглан дескриптив судалгааны аргаар хийж гүйцэтгэв.

Үр дүн: Судалгаанд хамрагдагсадын 42.6% нь 20-24 настай, 29.6% нь 25-29 настай, 27.8% нь 30-34 настай байв.


Хүснэгт 1. Инээмсэглэлийн үзүүлэлтүүдийг насны бүлэгтэй харьцуулсан байдал

	Ангилал	1-р бүлэг	2-р бүлэг	3-р бүлэг	Р Утга
Инээмсэглэлийн нум	Нийцтэй Шулуун Нийцтэй бус	78.26% 13.04% 8.7%	62.5% 37.5% 0.00%	60.0% 33.33% 6.67%	0.341
Инээмсэглэлийн хэлбэр	Бага Дунд Их Маш их	1.72% 39.66% 44.83% 17.39%	18.75% 37.5% 31.25% 12.50%	26.67% 40.0% 26.67% 6.67%	0.286
Инээмсэглэлийн тэгш хэм	Тэгш Тэгш бус	69.57% 30.43%	75.0% 25.0%	93.33% 6.67%	0.216
Хацрын корридор	Харагдана Харагдахгүй	52.17% 47.83%	37.50% 62.50%	40.0% 60.0%	0.610
Тайван үеийн харагдах байдал	Харагдана Харагдахгүй	0.00% 100.0%	0.00% 100.0%	0.00% 100.0%	


Судалгаанд нийт хамрагдагсадын инээмсэглэлийн нум нь 1, 2, 3-р бүлэгт нийцтэй. Инээмсэглэлийн хэлбэр нь 1-р бүлэгт их, 2-р бүлэгт дунд, 3-р бүлэгт дунд. Инээмсэглэлийн тэгш хэм нь 1, 2, 3-р бүлэгт тэгш. Хацрын корридор нь 1-р бүлэгт харагдана, 2, 3-р бүлэгт харагдахгүй. Тайван үеийн харагдах байдал 1, 2, 3-р бүлэгт харагдахгүй гэж тодорхойлогдсон байна. (Хүснэгт 1, Зураг 1-3)



Зураг 1. Инээмсэглэлийн нумын үзүүлэлтүүд



Зураг 2. Инээмсэглэлийн хэлбэр буюу хоншоорын үүдэн шүд харагдах байдал



Зураг 3. Хацрын корридор харагдах байдал

Хэлцэмж: Бид судалгаандаа Энглийн III ангилалын 54 хүнийг насны бүлгээр 3 хувааж, үзлэгийн картнаас хүн ам зүйн мэдээлэл, араа шүдний хоршилт, инээмсэглэлийн нум, инээмсэглэлийн хэлбэр, инээмсэглэлийн тэгш хэм, хацрын корридор, тайван үеийн хоншоорын үүдэн шүдний харагдах байдал зэрэг үзүүлэлтүүдийг ашиглан дескриптив судалгаа хийсэн. Инээмсэглэлийн нумын нийцтэй байдал нас ахих тусам эзлэх хувь буурч нийцтэй бус байдал нэмэгдэх хандлага ажиглагдсан. Инээмсэглэлийн хэлбэр буюу хоншоорын үүдэн шүд, буйлны харагдах байдал буурсан. Диккенс, Сарвер, Проффит нар 20 наснаас эхлэн инээмсэглэх ба тайван үед хоншоорын үүдэн шүд, буйны харагдах байдал нас ахих тусам буурдаг гэж тодорхойлсон нь бидний судалгааны үр дүнтэй нийцэж байв. Инээмсэглэлийн тэгш хэм нь насжилттай холбоогүй болох нь тодорхойлогдсон. Хацрын корридор нь 1-р бүлгийн хувьд харагдах бөгөөд 2-р бүлгээс эхлээд харагдахгүй болж байгаа нь насжилтаас үүсэх хатуу, зөөлөн эдийн өөрчлөлтөөс болж байгаагаар тодорхойлогдож байна.

Дүгнэлт

1. Энглийн III ангилалын зуултын гажгийн үед илрэх инээмсэглэлийн зарим үзүүлэлтүүдийн шинж тэмдгүүд нь инээмсэглэлийн үзүүлэлтүүдийн гоо зүйн хувьд нийцэж байна.
2. Энглийн III ангилалын зуултын гажгийн үед эрүүний араа шүдний хоршилт урагшилсанаас болон хоншоор ясны дутуу хөгжил зэргээс шалтгаалан инээмсэглэх үед хацрын корридорын харагдах байдал илүү байгааг харуулж байна.
3. Нас ахих тусам инээмсэглэлийн зарим үзүүлэлтүүдийн тохиромжтой шинж чанар нь буурдаг байна.
4. Нүүр амны их эмч нь үйлчлүүлэгч бүрийн нас, гажгийн төрлөөс хамаарах зөөлөн болон хатуу эдийн өөрчлөлтийн онцлогт тохируулан шүдний байрлал, зуултын харьцаа, үйл зүйг сэргээх эмчилгээг хийх нь зүйтэй юм.

Ном зүй:

1. *Goldstein RE. (1969). Study of need for esthetics in dentistry. J Prosthet Dent (21) 589-98.*
2. *Schabel BJ, Franchi L, Baccetti T, McNamara JA Jr. (2009). Subjective vs objective evaluations of smile esthetics. Am J Orthod Dentofacial Orthop 135(4) S72-9.*
3. *Thuy Anh Vu Pham, Phuc Anh Nguyen. (2022). Morphological features of smile attractiveness and related factors influence perception and gingival aesthetic parameters. International dental journal 72. 67-75*
4. *Daltro Enüas Ritter, Luiz Gonzaga Gandini Jr, Ary dos Santos Pinto, Dirceu Barnabü Ravelli, Arno Locks. (2006). World Journal of Orthodontics 7(3) 279-85.*
5. *Sarver DM. (2001). The importance of incisor positioning in the esthetic smile: The smile arc. Am J Orthod Dentofacial Orthop (120) 98–111.*
6. *Dr Binam Sapkota,1 Dr Shatakshi Srivastava,2 Dr Sushmit Koju,3 Dr Ritesh Srii4. Evaluation of Smile Line in Natural and Forced Smile Position: An Institution-based Study. Orthodontic Journal of Nepal, 2017;7;1*
7. *Morteza oshagh, Najafi H Zarif, F Bahramnia. Evaluation of the effect of buccal corridor size on smile attractiveness. Eur J Esthet dent, 2010;5(4);370-380*
8. *Garber DA, Salama MA. The aesthetic smile: Diagnosis and treatment. Periodontology 2000;11;8-28*
9. *Б.Золзаяа, Ж.Цолмон, Г.Ганжаргал, Н.Цэнгэлсайхан. (2021). Нүүр амны гажгийн тархалт. Эрдмийн чуулган-63 (17) 61-63*
10. *Б.Оюунжаргал, Д.Гантуяа, Б.Од. (2021). Нүүр ам судлалын төв эмнэлгийн нүүр амны гажиг заслын тасгийн үйлчлүүлэгчдийн шүд, эрүү нүүрний гажгийн төлөвийн судалгаа. Эрдмийн чуулган-63. (20) 53-58*
11. *Harpreet Grewal, Pranav Sapawat, Palash Modi, Sakshi Aggarwal. (2019). Psychological impact of orthodontic treatment on quality of life – A longitudinal study. International orthodontics. (17) 269–276*

Some characteristics of smile in people with Angle's class 3 malocclusion

Khulan G[1], Od B[2]
[1]Department of Orthodontics, School of Dentistry,MNUMS
Email: hulanganbold2@gmail.com
Tel: 99031029

Abstract

Background: The smile also influences a person's perceived attractiveness and is the cornerstone of social interaction. In traditional orthodontic treatment, orthodontists focus on teeth alignment, occlusal relationship, and function. Patients, however, are concerned about their facial esthetics, particularly smile esthetics. Most patients seek orthodontic treatment for esthetic purpose. Consequently, it is crucial for an orthodontist to be able to assess smile esthetics in a patient. So far, there have been no studies in the field of orthodontics that investigated the effect of smile esthetics on the different kinds of malocclusion for clinical reference. Therefore, in this study, our aim was to quantitatively assess the relationship of smile esthetic variables with angle class 3.

Objective: To study some characteristics of the smile of people with Angle's class 3 malocclusion.

Materials and Methods: A total of 54 patients who fulfilled the inclusion criteria were included in this study. The participants were divided into the following 3 groups according to their age. Group 1 (20-24), group 2 (25-29), group 3 (30-34).

Results: The smile arcs of all respondents consonant to groups 1, 2, and 3. The type of the smile is high in group 1, medium in group 2, and medium in group 3. The symmetry of the smile is symmetry in groups 1, 2 and 3. The buccal corridor is visible in group 1, but not in groups 2 and 3. The display at rest is defined as not visible in groups 1, 2, and 3.

Conclusions: Most of the smile variables differed significantly among different types of age group. Angle class 3 malocclusion shows greater appearance of the buccal corridor when smiling due to advanced mandibular molars and maxillary retrusion.

Keyword: Angle class III, smile analysis